ХӨВСГӨЛ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

# САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Хөвсгөл аймгийн Арбулаг сумын ЗДТГ-ын 2022 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

**Аудитын код:** ХӨА-2023/54/НА-СТА-ТШЗ

| | |
|---|---|
| Цахим хуудас: www.audit.mn<br>Мөрөн сум 2022 он | Хөвсгөл аймаг дахь Төрийн аудитын газрын дарга, тэргүүлэх аудитор: А.Эрдэнэбаатар<br>Утас: 88883317 Цахим хаяг:erdenebaatara@audit.gov.mn<br>Аудитын менежер: Б.Тэгшдэлгэр<br>Утас: 99089114 цахим хаяг:tegshdelgerb@audit.gov.mn<br>Аудитор: Л.Мандахнаран<br>Утас: 92118277 Цахим хаяг: MandakhnaranL@audit.gov.mn |

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

АГУУЛГА

1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ ..... 4
Асуудлыг онцолсон хэсэг ..... 4
Аудитын гол асуудал ..... 4
2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ ..... 6
3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА ..... 15
4. АУДИТЫН ТАЙЛАН ..... 18
4.1 Ерөнхий зүйл ..... 18
4.2 Материаллаг байдал ..... 18
4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт ..... 18
4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал ..... 18
4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт ..... 19
4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт ..... 19
4.5.1 Завсрын аудитын талаар ..... 19
4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал ..... 19
5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ ..... 20
5.3 Зөвлөмж ..... 20
6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ ..... 20

**Товчилсон үгийн жагсаалт**

| | |
|---|---|
| УСНББОУС | Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт |
| АДБОУС | Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт |
| ЗДТГ | Засаг даргын Тамгын газар |
| ИТХ | Иргэдийн төлөөлөгчдийн хурал |

**ХӨВСГӨЛ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

АЗДТГ-ын байр, А корпус 3 давхар,
Мөрөн сум, Хөвсгөл аймаг, 67120
Утас/факс:7038 3793, Цахим шуудан:khuvsgul@audit.gov.mn
Цахим хуудас: www.audit.mn

2023.02.24 № 01/173

танай ________ -ны № ________ -т

АРБУЛАГ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ТАМГЫН ГАЗРЫН ДАРГА Ц.ГАНХУЯГ
ТАНАА

**Өөрчлөлтгүй дүгнэлт**

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Арбулаг сумын Засаг даргын Тамгын газрын 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Арбулаг сумын Засаг даргын Тамгын газрын 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

**Дүгнэлтийн үндэслэл**

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

**Асуудлыг онцолсон хэсэг**

Тайлант оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх үндсэн хөрөнгийн дүн өмнөх оноос 166,778.7 мянган төгрөгөөр өссөн байна.

**Аудитын гол асуудал**

Арбулаг сумын ЗДТГ нь 2022 оны жилийн эцсийн санхүүгийн тайланд Хувь хүний орлогын албан татварын тооцооны 74.3 мянган төгрөгийн өр төлбөртэй байна.

**Бусад асуудлын хэсэг**

Арбулаг сумын Засаг даргатай 2022 оны гүйцэтгэлийн төлөвлөгөө байгуулж, түүнийг 94.1 хувьтай биелүүлж ажилласан байна.

**Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага**

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

**Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага**

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР А. ЭРДЭНЭБААТАР

## 2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

### 2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

| Дансны код | Балансын үзүүлэлт | Эхний үлдэгдэл | Эцсийн үлдэгдэл |
|---|---|---|---|
| **1** | **ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН** | **115,933,282.60** | **129,510,439.64** |
| 31211 | Төрийн сангийн харилцах | 00.00 | 00.00 |
| **35** | **БАРАА МАТЕРИАЛ** | 115,933,282.60 | 129,510,439.64 |
| **351** | **Түүхий эд материал** | 38,880,000.00 | 38,880,000.00 |
| 35110 | Тусгай зориулалттай материал | 38,880,000.00 | 38,880,000.00 |
| **354** | **Хангамжийн материал** | 75,858,282.60 | 88,715,439.64 |
| 35410 | Бичиг хэргийн материал | 28,500.00 | 00.00 |
| 35420 | Аж ахуйн материал | 14,949,054.00 | 22,823,554.00 |
| 35440 | Түлш, шатах тослох материал | 13,170,037.60 | 16,496,840.60 |
| 35450 | Барилгын засварын материал | 9,918,000.00 | 6,230,800.00 |
| 35470 | Бусад хангамжийн материал | 37,792,691.00 | 43,164,245.04 |
| 35600 | Мал амьтад | 1,195,000.00 | 1,915,000.00 |
| **2** | **ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН** | **1,063,086,413.49** | **1,216,287,952.48** |
| **39** | **ҮНДСЭН ХӨРӨНГӨ** | 1,063,086,413.49 | 1,216,287,952.48 |
| 391 | Газар | 00.00 | 00.00 |
| **392** | **Биет хөрөнгө** | 978,938,173.49 | 1,130,721,212.48 |
| 39201 | Барилга, байгууламж, орон сууц | 1,158,145,960.00 | 1,281,145,960.00 |
| 39202 | Хуримтлагдсан элэгдэл | -273,345,242.26 | -336,571,984.68 |
| 39203 | Авто-тээврийн хэрэгсэл | 138,205,492.00 | 130,376,809.00 |
| 39204 | Хуримтлагдсан элэгдэл | -109,975,364.71 | -72,453,514.76 |
| 39205 | Машин тоног төхөөрөмж (компьютер) | 186,194,063.20 | 149,608,215.60 |
| 39206 | Хуримтлагдсан элэгдэл | -129,044,687.38 | -39,667,746.62 |
| 39207 | Тавилга, аж ахуйн эд хогшил | 28,577,222.27 | 23,957,712.75 |
| 39208 | Хуримтлагдсан элэгдэл | -20,419,269.63 | -16,692,704.31 |
| 39214 | Бусад үндсэн хөрөнгө | 22,936,931.00 | 12,218,465.50 |
| 39215 | Хуримтлагдсан элэгдэл | -22,336,931.00 | -1,200,000.00 |
| **393** | **Биет бус хөрөнгө** | 84,148,240.00 | 85,566,740.00 |
| 39301 | Программ хангамж | 2,837,000.00 | 1,418,500.00 |
| 39302 | Хуримтлагдсан элэгдэл | -2,837,000.00 | 00.00 |
| **3** | **НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II** | **1,179,019,696.09** | **1,345,798,392.12** |
| **4** | **НИЙТ ӨР ТӨЛБӨР** | **31,714.08** | **74,345.23** |
| **41** | **БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР** | 31,714.08 | 74,345.23 |
| **413** | **Өглөг** | 31,714.08 | 74,345.23 |
| 41310 | Ажилчидтай холбогдсон өглөг | 31,714.08 | 74,345.23 |
| **5** | **ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН** | **1,178,987,982.01** | **1,345,724,046.89** |
| **51** | **Засгийн газрын хувь оролцоо** | 1,178,987,982.01 | 1,345,724,046.89 |
| 511 | Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан | 1,080,342,071.67 | 1,080,342,071.67 |
| 51101 | Өмч: - төрийн | 1,080,342,071.67 | 1,080,342,071.67 |

| | | | |
|---|---|---|---|
| 51102 | - хувийн | 00.00 | 00.00 |
| 51103 | - хувьцаат | 00.00 | 00.00 |
| **512** | **Хуримтлагдсан үр дүн** | -192,640,280.09 | -25,904,215.21 |
| 51210 | Өмнөх үеийн үр дүн | -192,640,280.09 | -192,640,280.09 |
| 51220 | Тайлант үеийн үр дүн | 00.00 | 166,736,064.88 |
| 51300 | Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү | 291,286,190.43 | 291,286,190.43 |
| **6** | **ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V** | **1,179,019,696.09** | **1,345,798,392.12** |

## 2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

| Дансны код | Үзүүлэлт | Өмнөх оны гүйцэтгэл | Тайлант оны гүйцэтгэл |
|---|---|---|---|
| **1** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)** | **482,408,622.00** | **904,607,490.85** |
| **12** | **ТАТВАРЫН БУС ОРЛОГО** | **87,256,718.00** | **257,710,990.85** |
| **120** | **Нийтлэг татварын бус орлого** | 87,256,718.00 | 257,710,990.85 |
| 120004 | Төсөв байгууллагын өөрийн орлого | 87,256,718.00 | 257,710,990.85 |
| 1200041 | Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих | 359,800.00 | 480,000.00 |
| 1200045 | Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого | 86,896,918.00 | 257,230,990.85 |
| **13** | **ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО** | **395,151,904.00** | **646,896,500.00** |
| **1311** | **Нэмэлт санхүүжилтийн орлого** | 12,777,404.00 | 8,989,400.00 |
| 131101 | Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж | 1,880,000.00 | 4,100,000.00 |
| 131104 | Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | 6,314,404.00 | 4,580,400.00 |
| 131105 | Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого | 4,583,000.00 | 309,000.00 |
| **1320** | **Орон нутгийн төсвөөс санхүүжих** | 382,374,500.00 | 637,907,100.00 |
| 132001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/ | 382,374,500.00 | 637,907,100.00 |
| **2** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН** | **475,969,503.54** | **738,601,425.97** |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | **475,969,503.54** | **550,843,053.97** |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | 465,603,630.67 | 510,277,099.86 |
| **2101** | **Цалин хөлс болон нэмэгдэл урамшил** | 261,277,523.65 | 272,790,589.60 |
| 210101 | Үндсэн цалин | 221,356,045.65 | 211,233,401.60 |
| 210102 | Нэмэгдэл | 39,456,200.00 | 36,215,044.00 |
| 210104 | Урамшуулал | 465,278.00 | 19,967,368.00 |
| 210105 | Гэрээт ажлын хөлс | 00.00 | 5,374,776.00 |
| **2102** | **Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл** | 35,236,867.88 | 35,686,616.30 |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 24,804,467.88 | 24,710,139.71 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 2,608,100.00 | 2,791,892.49 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 2,086,400.00 | 2,193,194.70 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 521,700.00 | 508,398.79 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 5,216,200.00 | 5,482,990.61 |
| **2103** | **Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал** | 19,820,779.68 | 24,490,000.00 |

| | | | |
|---|---|---|---|
| 210301 | Гэрэл, цахилгаан | 4,373,675.68 | 6,520,486.27 |
| 210302 | Түлш, халаалт | 15,247,104.00 | 17,490,000.00 |
| 210303 | Цэвэр, бохир ус | 200,000.00 | 479,513.73 |
| **2104** | **Хангамж, бараа материалын зардал** | 41,974,088.40 | 44,758,297.00 |
| 210401 | Бичиг хэрэг | 3,758,650.00 | 3,259,700.00 |
| 210402 | Тээвэр, шатахуун | 25,602,308.40 | 31,484,697.00 |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 3,458,390.00 | 3,530,000.00 |
| 210405 | Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал | 00.00 | 1,200,000.00 |
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | 4,650,632.00 | 5,005,900.00 |
| 210408 | Бараа материал акталсны зардал | 4,504,108.00 | 278,000.00 |
| **2106** | **Эд хогшил, урсгал засварын зардал** | 4,274,700.00 | 14,609,961.00 |
| 210604 | Урсгал засвар | 4,274,700.00 | 14,609,961.00 |
| **2107** | **Томилолт, зочны зардал** | 00.00 | 1,000,000.00 |
| 210702 | Дотоод албан томилолт | 00.00 | 1,000,000.00 |
| **2108** | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | 9,539,650.00 | 15,912,857.96 |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 7,786,650.00 | 13,440,059.96 |
| 210803 | Даатгалын үйлчилгээ | 220,000.00 | 191,850.00 |
| 210804 | Тээврийн хэрэгслийн татвар | 250,000.00 | 247,008.00 |
| 210805 | Тээврийн хэрэгслийн оношилгоо | 88,000.00 | 33,940.00 |
| 210806 | Мэдээлэл, технологийн үйлчилгээ | 435,000.00 | 1,000,000.00 |
| 210807 | Газрын төлбөр | 760,000.00 | 1,000,000.00 |
| **2109** | **Бараа үйлчилгээний бусад зардал** | 93,480,021.06 | 101,028,778.00 |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 2,525,911.00 | 10,510,626.14 |
| 210902 | Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх | 00.00 | 112,300.00 |
| 210903 | Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол | 90,954,110.06 | 90,405,851.86 |
| **213** | **УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ** | 10,365,872.87 | 40,565,954.11 |
| **2132** | **Бусад урсгал шилжүүлэг** | 5,569,248.00 | 28,230,484.00 |
| 213204 | Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал | 500,000.00 | 21,980,484.00 |
| 213209 | Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал | 5,069,248.00 | 6,250,000.00 |
| **2134** | **Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт** | 4,796,624.87 | 12,335,470.11 |
| 213403 | Төвлөрүүлэх шилжүүлэг | 4,796,624.87 | 12,335,470.11 |
| **22** | **ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ** | **00.00** | **187,758,372.00** |
| **2200** | **Дотоод эх үүсвэрээр** | 00.00 | 187,758,372.00 |
| 223001 | Бусад хөрөнгө | 00.00 | 187,758,372.00 |
| **3** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)** | **6,439,118.46** | **166,006,064.88** |
| **145** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ОРЛОГЫН ДҮН** | 743,100.00 | 730,000.00 |
| 145002 | Үндсэн хөрөнгө, бараа материал худалдсаны олз | 743,100.00 | 730,000.00 |
| **4** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145-225)** | 743,100.00 | 730,000.00 |
| **5** | **НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)** | **7,182,218.46** | **166,736,064.88** |

## 2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

| Дансны код | Үзүүлэлт | Өмнөх оны гүйцэтгэл | Тайлант оны гүйцэтгэл |
|---|---|---|---|
| **1** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)** | **395,151,904.00** | **646,896,500.00** |
| **13** | **ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО** | **395,151,904.00** | **646,896,500.00** |
| **1311** | **Нэмэлт санхүүжилтийн орлого** | 12,777,404.00 | 8,989,400.00 |
| 131101 | Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж | 1,880,000.00 | 4,100,000.00 |
| 131104 | Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | 6,314,404.00 | 4,580,400.00 |
| 131105 | Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого | 4,583,000.00 | 309,000.00 |
| **1320** | **Орон нутгийн төсвөөс санхүүжих** | 382,374,500.00 | 637,907,100.00 |
| 132001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/ | 382,374,500.00 | 637,907,100.00 |
| **2** | **НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)** | **393,989,704.00** | **457,938,128.00** |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | **393,989,704.00** | **457,938,128.00** |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | **385,610,079.13** | **417,372,173.89** |
| **2101** | **Цалин хөлс болон нэмэгдэл урамшил** | 261,275,277.45 | 255,924,075.89 |
| 210101 | Үндсэн цалин | 221,353,799.45 | 194,366,887.89 |
| 210102 | Нэмэгдэл | 39,456,200.00 | 36,215,044.00 |
| 210104 | Урамшуулал | 465,278.00 | 19,967,368.00 |
| 210105 | Гэрээт ажлын хөлс | 00.00 | 5,374,776.00 |
| **2102** | **Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл** | 35,209,400.00 | 31,729,400.00 |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 24,777,000.00 | 21,576,100.00 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 2,608,100.00 | 2,538,300.00 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 2,086,400.00 | 1,920,300.00 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 521,700.00 | 618,100.00 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 5,216,200.00 | 5,076,600.00 |
| **2103** | **Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал** | 24,373,675.68 | 27,000,000.00 |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 4,373,675.68 | 6,520,486.27 |
| 210302 | Түлш, халаалт | 19,800,000.00 | 20,000,000.00 |
| 210303 | Цэвэр, бохир ус | 200,000.00 | 479,513.73 |
| **2104** | **Хангамж, бараа материалын зардал** | 31,572,726.00 | 32,415,900.00 |
| 210401 | Бичиг хэрэг | 3,530,810.00 | 1,640,000.00 |
| 210402 | Тээвэр, шатахуун | 17,322,726.00 | 20,945,900.00 |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 3,779,190.00 | 3,530,000.00 |
| 210405 | Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал | 240,000.00 | 1,200,000.00 |
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | 6,700,000.00 | 5,100,000.00 |
| **2106** | **Эд хогшил, урсгал засварын зардал** | 9,377,700.00 | 6,900,000.00 |
| 210602 | Тавилга | 2,746,000.00 | 00.00 |
| 210604 | Урсгал засвар | 6,631,700.00 | 6,900,000.00 |

| | | | |
|---|---|---|---|
| **2107** | **Томилолт, зочны зардал** | | |
| 210702 | Дотоод албан томилолт | 00.00 | 1,000,000.00 |
| | | 00.00 | 1,000,000.00 |
| **2108** | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | 22,801,300.00 | 32,047,198.00 |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 21,048,300.00 | 29,574,400.00 |
| 210803 | Даатгалын үйлчилгээ | 220,000.00 | 191,850.00 |
| 210804 | Тээврийн хэрэгслийн татвар | 250,000.00 | 247,008.00 |
| 210805 | Тээврийн хэрэгслийн оношилгоо | 88,000.00 | 33,940.00 |
| 210806 | Мэдээлэл, технологийн үйлчилгээ | 435,000.00 | 1,000,000.00 |
| 210807 | Газрын төлбөр | 760,000.00 | 1,000,000.00 |
| **2109** | **Бараа үйлчилгээний бусад зардал** | 1,000,000.00 | 30,355,600.00 |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 1,000,000.00 | 29,162,500.00 |
| 210902 | Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх | 00.00 | 1,193,100.00 |
| **213** | **УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ** | **8,379,624.87** | **40,565,954.11** |
| **2132** | **Бусад урсгал шилжүүлэг** | 3,583,000.00 | 28,230,484.00 |
| 213204 | Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал | 500,000.00 | 21,980,484.00 |
| 213209 | Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал | 3,083,000.00 | 6,250,000.00 |
| **2134** | **Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт** | 4,796,624.87 | 12,335,470.11 |
| 213403 | Төвлөрүүлэх шилжүүлэг | 4,796,624.87 | 12,335,470.11 |
| **3** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)** | **1,162,200.00** | **188,958,372.00** |
| **5** | **ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)** | **1,162,200.00** | **188,958,372.00** |
| **22** | **ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ** | **1,162,200.00** | **188,958,372.00** |
| **2200** | **Дотоод эх үүсвэрээр** | 1,162,200.00 | 188,958,372.00 |
| 223001 | Бусад хөрөнгө | 00.00 | 187,758,372.00 |
| 225106 | Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал | 1,162,200.00 | 1,200,000.00 |
| **6** | **ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)** | **-1,162,200.00** | **-188,958,372.00** |
| **8** | **НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)** | 00.00 | 00.00 |
| **9** | **Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл** | 00.00 | 00.00 |
| **10** | **Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл** | 00.00 | 00.00 |

## 2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

| Үзүүлэлт | Засгийн газрын оруулсан капитал | Дахин үнэлгээний нөөц | Хуримтлагдсан дүн | Засгийн газрын хувь оролцооны нийт дүн |
|---|---|---|---|---|
| **2021 оны 01-р сарын 01-нээрх үлдэгдэл** | 996,193,831.67 | 42,878,900.00 | -164,160,849.86 | 874,911,881.81 |
| Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт | 00.00 | 00.00 | 2,224,700.00 | 2,224,700.00 |
| **Дахин илэрхийлсэн үлдэгдэл** | **996,193,831.67** | **42,878,900.00** | **-161,936,149.86** | 877,136,581.81 |
| Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт | 00.00 | -2,224,700.00 | 00.00 | -2,224,700.00 |
| Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний бууралт | 00.00 | 00.00 | 00.00 | 00.00 |
| Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз | 00.00 | 00.00 | 00.00 | 00.00 |
| Тайлант үеийн үр дүн | 00.00 | 00.00 | -17,673,130.52 | -17,673,130.52 |
| **2021 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл** | **1,080,342,071.67** | **291,286,190.43** | **-192,640,280.09** | 1,178,987,982.01 |
| **2022 оны 01-р сарын 01-нээрх үлдэгдэл** | **1,080,342,071.67** | **291,286,190.43** | **-192,640,280.09** | 1,178,987,982.01 |
| Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт | 00.00 | 00.00 | 00.00 | 00.00 |
| **Дахин илэрхийлсэн үлдэгдэл** | **1,080,342,071.67** | **291,286,190.43** | **-192,640,280.09** | 1,178,987,982.01 |
| Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт | 00.00 | 00.00 | 00.00 | 00.00 |
| Үндсэн хөрөнгийн өсөлт, бууралт | 00.00 | 00.00 | 00.00 | 00.00 |
| Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз | 00.00 | 00.00 | 00.00 | 00.00 |
| Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү | 00.00 | 00.00 | 00.00 | 00.00 |
| Тайлант үеийн үр дүн | 00.00 | 00.00 | 166,736,064.88 | 166,736,064.88 |
| **2022 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл** | **1,080,342,071.67** | **291,286,190.43** | **-25,904,215.21** | 1,345,724,046.89 |

## 2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

| Эдийн засгийн ангилал | Үзүүлэлт | Батлагдсан төлөвлөгөө | Гүйцэтгэл | Зөрүү |
|---|---|---|---|---|
| **2** | **НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН** | 437,907,100.00 | 437,813,257.89 | 93,842.11 |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | 437,907,100.00 | 437,813,257.89 | 93,842.11 |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | 410,126,600.00 | 410,032,773.89 | 93,826.11 |
| **2101** | **Цалин хөлс болон нэмэгдэл урамшил** | 253,832,700.00 | 253,824,075.89 | 8,624.11 |
| 210101 | Үндсэн цалин | 235,442,700.00 | 194,366,887.89 | 41,075,812.11 |

| | | | | |
|---|---|---|---|---|
| 210102 | Нэмэгдэл | 7,990,000.00 | 36,215,044.00 | (28,225,044.00) |
| 210104 | Урамшуулал | 00.00 | 17,867,368.00 | (17,867,368.00) |
| 210105 | Гэрээт ажлын хөлс | 10,400,000.00 | 5,374,776.00 | 5,025,224.00 |
| **2102** | **Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл** | 31,729,400.00 | 31,729,400.00 | - |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 21,576,100.00 | 21,576,100.00 | - |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 2,538,300.00 | 2,538,300.00 | - |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 1,920,300.00 | 1,920,300.00 | - |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 618,100.00 | 618,100.00 | - |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 5,076,600.00 | 5,076,600.00 | - |
| **2103** | **Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал** | 27,000,000.00 | 27,000,000.00 | - |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 6,800,000.00 | 6,520,486.27 | 279,513.73 |
| 210302 | Түлш, халаалт | 20,000,000.00 | 20,000,000.00 | - |
| 210303 | Цэвэр, бохир ус | 200,000.00 | 479,513.73 | (279,513.73) |
| **2104** | **Хангамж, бараа материалын зардал** | 26,169,600.00 | 26,169,600.00 | - |
| 210401 | Бичиг хэрэг | 1,500,000.00 | 1,570,000.00 | (70,000.00) |
| 210402 | Тээвэр, шатахуун | 18,969,600.00 | 18,899,600.00 | 70,000.00 |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 3,500,000.00 | 3,500,000.00 | - |
| 210405 | Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал | 1,200,000.00 | 1,200,000.00 | - |
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | 1,000,000.00 | 1,000,000.00 | - |
| **2106** | **Эд хогшил, урсгал засварын зардал** | 8,100,000.00 | 8,100,000.00 | - |
| 210601 | Багаж, техник, хэрэгсэл | 1,200,000.00 | 1,200,000.00 | - |
| 210604 | Урсгал засвар | 6,900,000.00 | 6,900,000.00 | - |
| **2107** | **Томилолт, зочны зардал** | 1,000,000.00 | 1,000,000.00 | - |
| 210702 | Дотоод албан томилолт | 1,000,000.00 | 1,000,000.00 | - |
| **2108** | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | 32,032,400.00 | 31,947,198.00 | 85,202.00 |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 29,474,400.00 | 29,474,400.00 | - |
| 210802 | Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох | 00.00 | 00.00 | - |
| 210803 | Даатгалын үйлчилгээ | 220,000.00 | 191,850.00 | 28,150.00 |
| 210804 | Тээврийн хэрэгслийн татвар | 250,000.00 | 247,008.00 | 2,992.00 |
| 210805 | Тээврийн хэрэгслийн оношлогоо | 88,000.00 | 33,940.00 | 54,060.00 |
| 210806 | Мэдээлэл, технологийн үйлчилгээ | 1,000,000.00 | 1,000,000.00 | - |
| 210807 | Газрын төлбөр | 1,000,000.00 | 1,000,000.00 | - |
| **2109** | **Бараа үйлчилгээний бусад зардал** | 30262500.00 | 30262500.00 | - |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 29,162,500.00 | 29,162,500.00 | - |
| 210902 | Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх | 1,100,000.00 | 1,100,000.00 | - |
| **213** | **УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ** | 27780500.00 | 27780484.00 | 16.00 |
| **2132** | **Бусад урсгал шилжүүлэг** | 27,780,500.00 | 27,780,484.00 | 16.00 |
| 213204 | Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал | 21,980,500.00 | 21,980,484.00 | 16.00 |
| 213209 | Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал | 5,800,000.00 | 5,800,000.00 | - |

| | | | | |
|---|---|---|---|---|
| **22** | **ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ** | **200,000,000.00** | **187,758,372.00** | 12,241,628.00 |
| **2200** | **Дотоод эх үүсвэрээр** | 200,000,000.00 | 187,758,372.00 | 12,241,628.00 |
| 223001 | Бусад хөрөнгө | 200,000,000.00 | 187,758,372.00 | 12,241,628.00 |
| | **ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР** | 637,907,100.00 | 625,571,629.89 | 12,335,470.11 |
| **1320** | **ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ** | 637,907,100.00 | 625,571,629.89 | 12,335,470.11 |
| 132001 | Орон нутгийн төсвөөс | 637,907,100.00 | 625,571,629.89 | 12,335,470.11 |
| **4** | **Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл** | 00.00 | 00.00 | - |
| **5** | **Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл** | 00.00 | 00.00 | - |
| **62** | **АЖИЛЛАГСАДЫН ТОО** | 26.00 | 26.00 | - |
| 620001 | Удирдах ажилтан | 03.00 | 03.00 | - |
| 620002 | Гүйцэтгэх ажилтан | 18.00 | 18.00 | - |
| 620003 | Үйлчлэх ажилтан | 05.00 | 05.00 | - |

## 2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

| Дансны код | Үзүүлэлт | Гүйцэтгэл |
|---|---|---|
| | **Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл** | |
| **I** | **НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН** | **8,989,400.00** |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | **8,989,400.00** |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | 8,539,400.00 |
| **2101** | **Цалин хөлс болон нэмэгдэл урамшил** | 2,100,000.00 |
| 210104 | Урамшуулал | 2,100,000.00 |
| **2104** | **Хангамж, бараа материалын зардал** | 6,246,300.00 |
| 210401 | Бичиг хэрэг | 70,000.00 |
| 210402 | Тээвэр, шатахуун | 2,046,300.00 |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 30,000.00 |
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | 4,100,000.00 |
| **2108** | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | 100,000.00 |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 100,000.00 |
| **2109** | **Бараа үйлчилгээний бусад зардал** | 93100.00 |
| 210902 | Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх | 93,100.00 |
| **213** | **УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ** | 450,000.00 |
| **2132** | **Бусад урсгал шилжүүлэг** | 450,000.00 |

| | | |
|---|---|---|
| 213209 | Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал | 450,000.00 |
| **II** | **ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР** | 8,989,400.00 |
| **1311** | **Нэмэлт санхүүжилтийн орлого** | 8,989,400.00 |
| 131101 | Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж | 4,100,000.00 |
| 131104 | Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | 4,580,400.00 |
| 131105 | Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого | 309,000.00 |
| **IV** | **НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(II)-(I)** | |
| | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл | |
| | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл | |

## 3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА

### 3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа

***Байгууллагын үйл ажиллагааны чиглэл, зорилго, зорилтын талаар:*** Арбулаг сумын ЗДТГ нь тухайн орон нутагт хууль журамд заасан чиг үүрийг орон нутагт хэрэгжүүлэх, ард иргэдийг мэдээллээр хангах үндсэн чиг үүрэгтэй ажиллаж байна. 2022 онд "Төсвийн хөрөнгийг үр ашигтай, хэмнэлттэй зарцуулах улмаар төрийн үйлчилгээг түргэн шуурхай, чанартай хүргэх үүднээс төрийн албан хаагчдыг мэргэшүүлэх, ажлын байран дээр нь чадваржуулах" гэсэн зорилго тавьж, түүнийгээ биелүүлэхийн тулд дараах зорилтуудыг дэвшүүлэн ажилласан байна. Үүнд:

1. Төр засгийн бодлого шийдвэрийг иргэдэд шуурхай хүргэх
2. Иргэдээс төрийн байгууллагад хандаж гаргасан өргөдөл гомдлыг шуурхай цаг хугацаанд шийдвэрлэх, хариуг хүргүүлэх
3. Төрийн албан хаагчдын нийгэм баталгааны хөтөлбөрийн хүрээнд албан хаагчдыг сургаж мэргэшүүлэх
4. Байгууллагын гадаад дотоод орчны тохижилт үйлчилгээг сайжруулах
5. Нийтлэг хуулиар хүлээсэн үүргийн хэрэгжилтийг хангуулах
6. Байгууллагын ил тод байдлыг хангах

*ЗДТГ-ын дарга нь нь сумын Засаг даргатай 2022 оны гүйцэтгэлийн төлөвлөгөө байгуулж, түүнийг 94.1 хувьтай биелүүлж ажилласан байна.*

### 3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин

***Байгууллагын үйл ажиллагаа явуулж буй хууль эрх зүйн орчны талаар:***

Тус байгууллага нь Төсвийн тухай хууль, Хувь хүний орлогын албан татварын тухай хууль, нийгмийн даатгалын шимтгэлийн тухай хууль, Засаг захиргаа нутаг дэвсгэрийн тухай хууль болон бусад хууль тогтоомж журам зааврыг мөрдөн ажилласан байна. Тайлант онд Төрийн хэмнэлтийн тухай хууль хэрэгжсэнтэй холбоотой байгууллагын үйл ажиллагаанд хэмнэлтийн горимыг баримталж ажилласан байна.

***Байгууллагын дотоод хяналтын талаар:***

Засгийн газрын 2011 оны 311 дүгээр тогтоолоор баталсан Аж ахуйн нэгж, байгууллагын үйл ажиллагаанд дотоод хяналт шалгалтыг зохион байгуулах нийтлэг журам"-ийн дагуу дотоод хяналт хэрэгжүүлэх ажлын хэсгийг 3 хүний бүрэлдэхүүнтэй байгуулсан байна.

Дотоод хяналтын ажлын хэсэг нь 2022 онд хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөө батлуулан, тухайн онд нийт 2 удаа дотоод хяналтыг хэрэгжүүлсэн байна. Дотоод хяналтаар илэрсэн зөрчлийг тухай бүр арилгаж ажилласан байна. Улирлд тутамд 1 удаа албан хаагчдад сургалт зохион байгуулсан байна.

Харин санхүүгийн үйл ажиллагаанд дотоод хяналтын 2 үе шатны тогтолцоо бий болсон байна гэж үзлээ. ***Тухайлбал:*** Санхүүгийн үйл ажиллагаанд гүйцэтгэх удирдлага буюу Засаг даргын Тамгын газрын дарга 1 дүгээр гарын үсэг, нягтлан бодогч 2 дугаар гарын үсэг зурж баталгаажуулж гүйцэтгэх удирдлагын хяналтыг хэрэгжүүлж байна. Мөн сумын Төрийн сангийн мэргэжилтэн гүйлгээ тус бүрээр хяналт хийж, санхүүгийн албаны дарга гүйлгээг баталж байна.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж буй дотоод хяналтаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна гэж үзлээ.

Тайлант онд дээд шатны төсвийн захирагчийн дотоод аудитын чиг үүрэг хэрэгжүүлэх нэгжээс хяналтыг хэрэгжүүлээгүй тул аудитад ашиглах дотоод аудитын гүйцэтгэл, ажлын үр дүнгийн тайлан зэрэг баримт материал байхгүй байна.

### 3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Арбулаг сумын ЗДТГ-ын 2022 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэж, Төсвийн тухай хуулийн 54.4, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 8 дугаар зүйлд заасан иж бүрдийн дагуу бэлтгэж толилуулсан байна гэж үзлээ.

Харин төсвийн гүйцэтгэлийн тайланг мөнгөн сууриар бэлтгэж, Төсвийн тухай хуулийн 54 дүгээр зүйлийн 54.5 дахь заалтад заасан заалтын дагуу иж бүрэн ирүүлсэн.

***Байгууллагын мөрдөж буй нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийн талаар:*** Санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаандаа Хөвсгөл аймгийн Засаг даргын 2019 оны А/375 дугаар захирамжаар баталсан “Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг”-ийг үйл ажиллагаандаа ашиглаж байна. Тус Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичигт тусгагдсан зарим журам заавар шинэчлэгдсэн, боловсролын салбарын байгууллагуудын төсвийн шатлалд өөрчлөлт орсонтой холбоотой нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг өөрийн байгууллагын үйл ажиллагаандаа тохируулан боловсруулах шаардлага тулгарч байна.

Гэхдээ санхүү, төсөв нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаандаа УСНББОУС, Засгийн газар, Сангийн яамнаас гаргасан журам, зааврыг мөрдөж ажилласан байна.

### 3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд

Арбулаг сумын ЗДТГ-ын 2022 оны жилийн эцсийн санхүүгийн тайланг Сангийн сайдын 2006 оны 388 дугаар тушаалаар баталсан “Төсөвт байгууллагад мөрдөх нягтлан бодох бүртгэлийн дансны заавар”-ын дагуу бэлтгэсэн байна. Тайлант хугацаанд нягтлан бодох бүртгэлийн бодлогод өөрчлөлт ороогүй байна.

Тайлант оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 166,778.7 мянган төгрөгөөр өссөн байна.

*Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт*

/мянган төгрөгөөр/

| Үзүүлэлт | Эхний үлдэгдэл | Эцсийн үлдэгдэл | Өөрчлөлт |
|---|---|---|---|
| Б | | | |
| Мөнгөн хөрөнгө | 0.0 | 0.0 | 0.0 |
| Авлага | 0.0 | 0.0 | 0.0 |
| Бараа материал | 115,933.3 | 129,510.4 | 13,577.1 |
| Үндсэн хөрөнгө | 1,063,086.4 | 1,216,287.9 | 153,201.5 |
| **Нийт хөрөнгө** | **1,179,019.7** | **1,345,798.4** | **166,778.7** |
| Өр төлбөр | 31.7 | 74.3 | 42.6 |
| Засгийн газрын хувь оролцоо /Эздийн өмч/ | 1,178,987.9 | 1,345,724.0 | 166,736.1 |
| **Өр төлбөр ба цэвэр хөрөнгө/өмчийн дүн** | **1,179,019.7** | **1,345,798.4** | **166,778.7** |

Дээрх хүснэгтээс харахад үндсэн хөрөнгө данс 153,201.5 мянган төгрөгөөр өссөн нь тайлант онд нийт хөрөнгийн дүн өсөхөд гол нөлөө үзүүлсэн байна.

Өр төлбөр дансны үлдэгдэл 42.6 мянган төгрөгөөр нэмэгдэж 74.3 мянган төгрөг болсон байна. 2022 оны жилийн эцсийн тайлангаар өр, төлбөртэй байгаа нь “Төсвийн тухай хууль”-ийн 6 дугаар зүйлийн 6.4.8 дахь "Төсвийг зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй байх" заалттай нийцэхгүй байна.

*Шийдвэрлэсэн нь: Зөвлөмж хүргүүлэв.*

### 3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

#### 3.5.1 Төсвийн төлөвлөлт

Тус байгууллагын 2022 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг орон нутгийн төсвөөс 641,023.9 мянган төгрөгөөр тооцон төлөвлөж дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Арбулаг сумын ИТХ-ын 2021 оны 12 дугаар сарын 17-ны өдрийн 11 дүгээр тогтоолоор төсвийн төслийн саналаас орон нутгийн төсвөөр санхүүжүүлэх дүнг 25,059.0 мянган төгрөгөөр бууруулж 615,964.6 мянган төгрөгөөр баталсан байна.

#### 3.5.2 Төсвийн гүйцэтгэл

Тайлант оны батлагдсан орон нутгийн төсвөөс баталсан төсвийг 21,942.2 мянган төгрөгөөр нэмэгдүүлж, тодотгосон байна.

Тайлант онд 3 хөтөлбөрийн 7 арга хэмжээг хэрэгжүүлж ажилласан байна.

Гүйцэтгэлээр орон нутгийн төсвөөс 637,907.1 мянган төгрөгийн санхүүжилт хүлээн авч зарцуулаагүй үлдэгдэл 12,335.0 мянган төгрөгийг буцаан төвлөрүүлсэн байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 625,571.1 мянган төгрөг буюу 98.0 хувьтай байгаа нь бараа үйлчилгээний зардлын төсвийг 12,241.0 мянган төгрөгөөр дутуу зарцуулсантай холбоотой байна.

*Хүснэгт 2. Хөтөлбөр, арга хэмжээний төлөвлөгөө, гүйцэтгэл*

/мянган төгрөгөөр/

| д/д | Хөтөлбөр | Арга хэмжээ | Төлөвлөгөө | Гүйцэтгэл | Зөрүү | Биелэлт |
|---|---|---|---|---|---|---|
| 1 | Орон нутгийн гүйцэтгэх удирдлага | 80101 Үндсэн үйл ажиллагаа | 323,110.7 | 323,016.8 | 93.9 | 99.9% |
| 2 | | 80106 Баг хорооны үйл ажиллагааны зардал | 69,030.9 | 69,030.9 | 0.0 | 100% |
| 3 | | 80802 Ажил олгогчоос олгох тэтгэмж | 27,780.5 | 27,780.5 | 0.0 | 100% |
| 4 | | 82801 Улсын баяр наадмын зардал | 5,000.0 | 5,000.0 | 0.0 | 100% |
| 5 | Орон нутгийн зорилтот хөрөнгө оруулалт | 81102 Орон нутгийн нөөц хөрөнгө | 15,000 | 15,000.0 | 0.0 | 100% |
| 6 | | 80918 Орон нутгийн зорилтот хөрөнгө оруулалт | 200,000.0 | 187,758.0 | 12,242.0 | 93.9% |
| 7 | Байгаль хамгаалах нөхөн сэргээх | 81701 Байгаль орчныг хамгаалах нөхөн сэргээх зардал | 6,674.4 | 6,674.4 | 0.0 | 100% |

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

#### 3.5.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Арбулаг сумын ЗДТГ нь 2022 онд нэмэлт санхүүжилтээр мал тооллогын ажлын санхүүжилт 4,580.4 мянган төгрөг, тендерийн баримт бичгийн орлого 309.0 мянган төгрөг, бусад орлого 4,100.0 мянган төгрөг, нийт 8,989.4 мянган төгрөгийг төвлөрүүлсэн байна. Дээрх

санхүүжилтийн орлогыг баталсан удирдамж, зориулалтын дагуу зарцуулалтын эрх нээлгэж зарцуулсан байна.

Нэмэлт төсвийн тайланг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.6-д харуулав.

### *3.5.4 Төсөл хөтөлбөрийн үе шат, хүрэх үр дүн*

2022 онд гадаад, дотоодын эх үүсвэрээр ямар нэгэн төсөл хөтөлбөр хэрэгжээгүй байна.

## 4. АУДИТЫН ТАЙЛАН

### 4.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д "Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана." гэж заасны дагуу Арбулаг сумын ЗДТГ-ын 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд аудит хийгдэх байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн буруу илэрхийлэл, түүнийг шийдвэрлэсэн байдал, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудиторын дүгнэлт, дүгнэлтийн үндэслэлийг хураангуйлан толилуулав. Мөн байгууллагын үйл ажиллагааг сайжруулахтай холбоотой өгсөн зөвлөмжүүдийг тусгасан болно.

Аудитыг Хөвсгөл аймаг дахь Төрийн аудитын газрын аудитор Л.Мандахнаран гүйцэтгэж, аудитын менежер Б.Тэгщдэлгэр анхан шатанд хянаж, тэргүүлэх аудитор А.Эрдэнэбаатар дараагийн шатны хяналтыг хэрэгжүүлсэн.

Арбулаг сумын ЗДТГ-ын 2022 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг 2023 оны 01 дүгээр сарын 25-ны өдрийн 3/31 дүгээр албан бичгээр ирүүлсэн байна.

### 4.2 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэлийг Дунд гэж үнэллээ.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2021 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардал 476,408.6 мянган төгрөгөөс 1.5 хувиар буюу 7,140.2 мянган төгрөгөөр, тогтоосныг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

### 4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт

Төрийн хэмнэлтийн тухай хууль хэрэгжиж эхэлсэнтэй холбоотойгоор байгууллага Тэргүүн дэд, дэд, орлогч дарга, тээврийн хэрэгсэл, албан тасалгаа, дүрэмт хувцас, албан томилолт, нэг удаагийн мөнгөн тэтгэмж, бусад хангамж, цахим худалдан авалт, Төсвийн байгууллага, төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээдэд хориглосон зарим асуудал, Төсвийн байгууллага, төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээдийн авч хэрэгжүүлэх арга хэмжээний нийт 29 асуудлаар хяналтыг хэрэгжүүлэхэд зөрчилтэй зүйл илрээгүй болно.

### 4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

#### 4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан "Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам"-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Арбулаг сумын ЗДТГ-ын 2022 онд Шилэн дансны нэгдсэн цахим хуудсанд оруулах мэдээллийг хугацаанд нь бүрэн оруулж ажилласан байна.

Цалингийн зардлаас бусад 5 сая төгрөгөөс дээш орлого, зардлын гүйлгээг мэдээлсэн байдлыг хянахад орлогын 625,394.2 мянган төгрөгийн 31 гүйлгээний мэдээлэл, зарлагын 224,123.9 мянган төгрөгийн 7 гүйлгээний мэдээллийг хугацаанд нь бүрэн оруулж ажилласан байна.

#### 4.4.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

Арбулаг сумын ЗДТГ нь 2022 онд Сангийн сайдын 2021 оны 190 дүгээр тушаалаар баталсан "Зардлын эдийн засгийн ангилал ашиглах заавар"-ыг зөрчиж 1,188.0 мянган төгрөгийг зарцуулсан байна.

*<u>Шийдвэрлэсэн нь</u>*: Зөвлөмж хүргүүлсэн

### 4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

#### 4.5.1 Завсрын аудитын талаар

Арбулаг сумын ЗДТГ-ын 2022 оны санхүүгийн үйл ажиллагаанд завсрын аудит хэрэгжүүлээгүй болно.

#### 4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн

Өмнөх аудитаар өгсөн 1 зөвлөмжийг бүрэн хэрэгжүүлж ажилласан байна.

*Хүснэгт 4 Төлбөрийн акт,* албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт

/мянган төгрөгөөр/

| Үзүүлэлт | Өмнөх аудитын үзүүлэлт | | Биелэлт | | |
|---|---|---|---|---|---|
| | Тоо | Дүн | Тоо | Дүн | Хувь |
| Акт | 0 | 0 | 0 | 0 | 0 |
| Албан шаардлага | 0 | 0 | 0 | 0 | 0 |
| Зөвлөмж | 1 | 0 | 1 | 0 | 100 |
| Нийт дүн | 1 | 0 | 1 | 0 | 100 |

### 4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Дараагийн аудитаар анхаарал хандуулах асуудал байхгүй байна.

## 5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар санхүүгийн тайлангийн толилуулгыг илэрхийлэхдээ нягтлан бодох бүртгэлээс зөрүүтэй илэрхийлсэн байсныг аудитын хугацаанд залруулсан болно.

Аудитаар нийт 1,262.3 мянган төгрөгийн зөрчил[1] илрүүлж, дахин давтахгүй байх 2 зөвлөмж өгсөн.

### 5.1 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дараалаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

***1. Өр төлбөртэй холбоотой асуудал***

***<u>Илрүүлэлт</u>:***

Арбулаг сумын ЗДТГ нь 2022 оны жилийн эцсийн санхүүгийн тайланд ХХОАТ-ын тооцооны 74.3 мянган төгрөгийн өр төлбөртэй байна.

Энэ нь төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.8 дахь "Төсвийг зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй байх" заалттай нийцэхгүй байна.

***<u>Өгсөн зөвлөмж</u>:***

Төсвийг зохистой удирдаж өр, төлбөр үүсгэхгүй байх

***2. Төсвийн зарцуулалттай холбоотой асуудал***

***<u>Илрүүлэлт:</u>***

Арбулаг сумын ЗДТГ нь Сангийн сайдын 2021 оны 190 дүгээр тушаалаар батлагдсан "Зардлын эдийн засгийн ангилал ашиглах заавар"-ыг зөрчиж 1,188.0 мянган төгрөгийг зарцуулсан байна.

***<u>Өгсөн зөвлөмж:</u>***

Төсвийг баталсан эдийн засгийн ангиллын дагуу зарцуулж ажиллах

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2023 оны 9 дүгээр сарын 20 -ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

## 6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

**Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл**

/мянган төгрөгөөр/

| Алдааны товч утга | Нийт алдаа | | Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан | | Буруу тусган илэрхийлсэн | | Үүнээс | | | | Зөвлөмж | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | Залруулсан | | Залруулаагүй | | | |
| | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн |
| 0 | 0 | 0 | 0 | 0 | 0 | 0 | 0 | 0 | 0 | 0 | 0 | 0 |
| Дүн | | | | | | | | | | | | |

[1] Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

**Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл**

/мянган төгрөгөөр/

| Зөрчлийн товч утга | Нийт зөрчил | | Үүнээс | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | Төлбөрийн акт | | Албан шаардлага | | Зөвлөмж | | Хариуцлага тооцуулах албан шаардлага | | Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал | |
| | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Албан тушаалтны тоо | Тоо | Дүн |
| Өр төлбөр | 1 | 74.3 | | | | | 1 | 74.3 | | | | 0 |
| Төсвийн зарцуулалт | 1 | 1,188.0 | | | | | 1 | 1,188.0 | | | | |
| ***Дүн*** | ***2*** | ***1,262.3*** | | | | | ***2*** | ***1,262.3*** | | | | |

**Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал**

/мянган төгрөгөөр/

| Зөрчлийн товч утга | Нийт зөрчил | | Үүнээс | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | Төлбөрийн акт | | Албан шаардлага | | Зөвлөмж | |
| | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн |
| Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил | | | | | | | | |
| Хугацаа хоцроож мэдээлсэн | | | 0 | 0 | 0 | 0 | | |
| Мэдээлээгүй | | | 0 | 0 | 0 | 0 | | |
| ***Дүн*** | | | ***0*** | ***0*** | ***0*** | ***0*** | | |
| Бусад хууль тогтоомжтой холбоотой зөрчил | | | | | | | | |
| Норм норматив баримтлаагүй | | | | | | | | |
| ***Дүн*** | | | | | | | | |
| ***Нийт дүн*** | | | | | | | | |

АУДИТЫГ ТАЙЛАНГ

БАТАЛГААЖУУЛСАН:

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР А.ЭРДЭНЭБААТАР

ХЯНАСАН:

АУДИТЫН МЕНЕЖЕР Б.ТЭГШДЭЛГЭР

АХЛАХ АУДИТОР Б.ДАВААНЯМ

БОЛОВСРУУЛСАН:

АУДИТОР Л.МАНДАХНАРАН